213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	8,516,276.00	0
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		7,556,397.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	84,600,881.00	21,943,645.00
2200	Дотоод эх үүсвэрээр	84,600,881.00	21,943,645.00
221001	Их засвар	49,200,000.00	0
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	35,400,881.00	21,943,645.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	121,218,213.00	202,662,136.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	121,218,213.00	202,662,136.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	49,200,000.00	18,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,383,832.00	17,632,115.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	55,248,481.00	79,750,645.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	12,385,900.00	12,661,376.00
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого		74,618,000.00
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		0
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		0
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		0

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Мөст сумын ТТЗ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд ОНХС-гийн хөрөнгөөр иргэдийн санал аваагүй ажил үйлчилгээг санхүүжүүлсэн, гамшгийн зардал санхүүжүүлсэн, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангагдаагүй, Засгийн газрын 43 тоот тогтоолыг хэрэгжүүлэн ажиллаагүй, бараа материалын тайлан гаргаагүй, дотоод хяналтын хэрэгжүүлэн ажиллаагүй, СХС-гийн хугацаа хэтэрсэн зээлдэгч нараар зээлийг эргүүлэн төлүүлээгүй зэрэгтэй холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг ахлах аудитор Д.Мөнхтулга 2022 оны 3 дугаар сарын 17-ноос 2022 оны 03 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Мөст сумын Засаг дарга 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн 1/25 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Мөст сумын засаг дарга нь Монгол улсын Үндсэн хууль болон УИХ, Засгийн газраас гарч буй хууль тогтоомжид нийцүүлэн төрийн үйлчилгээг ард иргэдэд түргэн шуурхай, ил тод нээлттэй, чанартай, тэгш хүргэж ажилгүйдэл, ядуурлыг бууруулан, иргэд, айл өрхүүдийн амьжиргааг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх, иргэдийн эрүүл мэндийн байдлыг хамгаалах, сумын ард иргэдийг ундны цэвэр усаар хангах гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Аймгийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд сумынхаа эдийн засаг, нийгмийн хөгжлийг эрчимжүүлж, байгаль орчин, бизнест ээлтэй ногоон хөгжлийн бодлого хэрэгжүүлэх
- Төрийн үйлчилгээг чанарын шинэ шатанд гаргаж, ард иргэдийнхээ амьдрах орчныг сайжруулах, аж амьдралыг дээшлүүлэх олон талт үйл ажиллагаа явуулах
- Мал аж ахуйг эрчимжүүлэх, залуу малчдыг малжуулах гэсэн олон талт үйл ажиллагаа явуулах

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Малын тоо толгойн албан татварын тухай хууль*
- *Нийгмийн даатгалын сангийн 2021 оны төсвийн тухай хууль*
- *Эрүүл мэндийн даатгалын сангийн 2021 оны төсвийн тухай хууль*
- *Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай*

- *Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор “төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөө багатай байна.

Сумын нэгтгэсэн санхүүгийн тайланд мөрдөх тусгайлан баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй бөгөөд Сангийн яамнаас гаргасан бодлого шийдвэрүүдийг хэрэгжүүлэн и-баланс цахим программ хангамж ашиглан холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцүүлэн, үйл ажиллагааны онцлогт тохируулан ашиглаж байна.

Мөст сумын Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Засаг даргын дэргэдэх санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас дотоод хяналт хэрэгжүүлээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мөст сумын ТТЗ-ын 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2021 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт орлогын 3,365.4 сая төгрөгөөс 1.5 хувиар тооцон 50.5 сая төгрөгөөр материаллаг байдлыг тооцон, санхүүгийн тайлангийн түвшинд гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 40.4 сая төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Мөст сумын ТТЗ-ын 2021 оны нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 976.3 сая төгрөгөөр буюу 17 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, цэвэр хөрөнгө, өмчийн данснууд байна.

Хүснэгт №1. Санхүүгийн байдлын тайлан

/сая төгрөг/

Тайлангийн үзүүлэлтүүд	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	
Мөнгөн хөрөнгө	114.1	233.0	-118.90	204%
Авлага	451.1	421.6	29.50	93%

Бараа материал	132.0	328.6	-196.60	249%
Үндсэн хөрөнгө	5,199.7	5,890.0	-690.30	113%
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	5,896.9	6,873.2	-976.30	117%
Богино хугацаат өр төлбөр	14.5	78.5	-64.00	541%
Цэвэр хөрөнгө, өмч	5,882.4	6,794.7	-912.30	116%
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	5,896.9	6,873.2	976.30	117%

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 114.1 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 233.0 сая төгрөг болж 118.9 сая төгрөгөөр буюу 104 хувиар өссөн байна. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 169.4 сая төгрөг нь Төрийн сангийн харилцах дансанд 10.1 сая төгрөг нь ОНХС-ийн дансанд, СХС-ийн дансанд 52.8 сая төгрөг, хүн эмнэлгийн дансанд 0.6 сая төгрөг байршиж байна.

3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 230.4 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 244.1 сая төгрөг болж 13.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №02 Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	0.30	4.8	4.5
Төлбөртэй үйлчилгээний авлага		22.2	22.2
Байгууллагаас авах авлага	1.40	45.9	44.5
Хувь хүмүүсээс авах авлага	0.50		(0.5)
Зээлийн хүүгийн авлага	219.4	171.1	(48.3)
Татвар, НДШ /ОНӨААТҮГ/	0.3		(0.3)
Татаас санхүүжилтын авлага	8.5	-	(8.5)
Дүн	230.4	244.0	13.6
Урьдчилж гарсан зардал	89.5	89.5	-
Тусгай зориулалтын сан	131.2	88.0	(43.2)
Дүн	220.7	177.5	

Эх сурвалж: Мөст сумын ТТЗ-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт авлагын дийлэнхийг сум хөгжүүлэх сангийн зээл, зээлийн авлага эзэлж байгаа бөгөөд оны эхэнд 219.4 сая төгрөгийн зээлийн авлагын үлдэгдэлтэй байсан ба тайлант онд 15.0 сая төгрөгийн зээл олгож, 69.2 сая төгрөгийн зээл, зээлийн хүү эргэн төлөгдөж, оны эцэст 171.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

ОНХС-гийн авлага оны эхний үлдэгдэл 220.7 сая, оны эцэст 204.5 сая төгрөг болж 16.2 сая төгрөгөөр буурсан байна. Оны эхний авлагаас 43.2 сая төгрөгийн ажлыг хүлээн авч, тайлант онд дутуу ажлын 27.0 сая төгрөгийн авлага нэмэгджээ. ОНХС-д олон жилийн насжилттай 80.0 сая төгрөгийн замын зураг төсвийн урьдчилгаа, 86.0 сая төгрөгийн 27 иргэнтэй холбоотой 86.0 сая төгрөгийн малжуулах хөтөлбөрийн урьдчилгаа, 2017 онд хэрэгжсэн хашаа хөтөлбөртэй холбоотой 14 иргэнээс авах 3.5 сая төгрөгийн урьдчилгаа байна.

3.5.3 Бараа материал

Бараа материалын дансны эхний үлдэгдэл 132.0 сая төгрөг, оны эцэст 328.6 сая төгрөг болж 196.6 сая төгрөгөөр буюу 149 хувиар өссөн байна.

Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 380.3 сая төгрөгийн бараа материалыг төсвийн хөрөнгөөр худалдан авч Мөст сумын сум дундын эмнэлэг улсын төсвөөс орон

нутгийн төсөвт шилжин ирсэнтэй холбоотой 86.0 сая төгрөгийн бараа материалыг шилжүүлэн авч, хандив тусламжаар 15.1 сая төгрөг нийт 481.4 сая төгрөгөөр нэмэгдэж, 284.8 сая төгрөгийн материалыг зарцуулсан байна. Бараа материал өсөлтөд эмнэлгийн 135.9 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэл голлох нөлөөг үзүүлжээ.

3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 6,941.9 сая төгрөг байсан бол оны эцэст 8,153.8 сая төгрөг болж 1,211.9 сая төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 25.6 сая төгрөгийн хөрөнгө худалдан авч эмнэлгийн 812.8 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн авч 420.8 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч дуусаагүй барилгаас 49.2 сая төгрөгийн хөрөнгийг тайлант онд хүлээн авсантай холбоотой байна.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолоор 48.3 сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлээс хассан байна.

3.5.6 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 14.5 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 78,5 сая төгрөг болж 64.0 сая төгрөгөөр өссөн байна.

Богино хугацаат өр төлбөр өссөн шалтгаан нь эмнэлгийн 73.3 сая төгрөгийн өр төлбөрийн өглөгтэй холбоотой байна.

3.5.7 Цэвэр хөрөнгө, өмч

Засгийн газрын оролцоо дансны оны эхний үлдэгдэл 5,882.4 сая төгрөг, оны эцэст 6,794.7 сая төгрөг болж тайлант онд 912.3 сая төгрөгөөр өссөн нь эмнэлгийн төрийн өмч 176.8 сая, дахин үнэлгээний нэмэгдэл данс 414.9 сая, хуримтлагдсан үр дүн 67.0 сая төгрөгөөр нэмэгдэж тайлант үеийн үр дүн 253.6 сая төгрөг болсонтой холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Мөст сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны нэгтгэсэн төсвийг аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 03 өдрийн 3/03 тоот тогтоолоор 2,581.7 сая төгрөгөөр анх баталжээ. Цар тахалтай холбоотойгоор 2021 онд 1 удаа тодотгол хийн 2021 оны 8 сарын 05-ны 4/03 тоот тогтоолоор нийт 2,689.8 сая төгрөгөөр баталсан байна.

Төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,689.8 сая төгрөгөөр, нийт зарлагыг 2,689.8 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн тодотголыг сумын ИТХ-аар 2021 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн 3/03 тоот тогтоолоор 2,689.8 сая төгрөгөөр 6 байгууллага, 2 сангийн төсвийг тодотгож баталжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 2,689.8 сая төгрөгийн төсөв баталснаас 1,824.4 сая төгрөгийг улсын төсвөөс, 606.3 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, ОНХС-аас 120.4 сая төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 36.9 сая төгрөг, 0.6 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор, туслах үйл ажиллагааны орлогоос 40.5 сая, урьд оны үлдэгдлээс 60.7 сая төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Мөст сумын ИТХ-ын 2021 оны орон нутгийн төсөв батлах тухай 2021 оны 8 дүгээр сарын 12-ны өдрийн 3/03 дугаар тогтоолд Мөст сумын Төвлөрүүлэн захирагчийн тайлант онд 163.0 сая төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 298.2 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 182.9 хувиар биелүүлсэн байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,774.3 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 582.5 сая төгрөг, ОНХС-аас 120.4 сая төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 36.9 үндсэн үйл ажиллагааны орлого 0.6 сая төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 69.9 сая нийт 2,584.6 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 2,581.7 сая төгрөгийг зарцуулжээ.

Нэр төрөл	төлөвлөгөө	гүйцэтгэл	зөрүү
Улсын төсвөөс санхүүжих	1,824.4	1,774.3	50.1
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,824.4	1,774.3	50.1
Орон нутгийн төсвөөс санхүүжих	726.7	702.9	23.8
Орон нутгийн төсвөөс	606.3	582.5	23.8
Орон нутгийн хөгжлийн сан	120.4	120.4	0
Нийгмийн даатгалын төсвөөс санхүүжих	36.9	36.9	2.9
Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	36.9	36.9	2.9
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	101.8	70.5	31.3
Үндсэн үйл ажиллагааны орлогоос	0.6	0.6	0
Туслах үйл ажиллагааны орлогоос	40.5	69.9	-29.4
Урьд оны үлдэгдлээс санхүүжих	60.7	0	60.7
ЭХ ҮҮСВЭРИЙН НИЙТ ДҮН	2,689.80	2,584.60	57.83

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,581.7 сая төгрөг буюу 96 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 40,6 сая төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 11.8 сая төгрөгөөр, бараа хангамж, бараа материалын зардал 0.7 сая төгрөгөөр ,нормативт зардлыг 17.0 сая төгрөгөөр, томилолтын зардал 4.6 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 0.2 сая төгрөгөөр ,хөрөнгийн зардлыг 10.0 сая төгрөгөөр,эргэж төлөгдөх зээлийг 23.7 сая төгрөгөөр хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн үйл ажиллагааны орлогыг 0.6 сая туслах үйл ажиллагааны орлого 40.5 сая төгрөгөөр тус тус батлагдаж гүйцэтгэлээр үндсэн үйл ажиллагааны орлогыг 0.6 сая, туслах үйл ажиллагааны орлогыг 69.9 сая төгрөгөөр нийт 70.5 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Мөст сумын ИТХ-ын 2021 оны орон нутгийн төсөв батлах тухай 2021 оны 8 дүгээр сарын 12-ны өдрийн 3/03 дугаар тогтоолд Мөст сумын Төвлөрүүлэн захирагчийн тайлант онд 163.0 сая төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 298.2 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 182.9 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 3. Сумын татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

/Сая.төгрөг/

Орлогын ангилал	2021 оны		Зөрүү
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
Татварын орлого	163.0	298.2	(135.2)
Орлогын албан татвар	11.5	21.3	(9.8)
Хувь хүний орлогын албан татвар	6.5	6.0	0.5
Үйл ажиллагааны орлого	2.0	11.7	(9.7)
Шууд бус орлого	3.0	3.6	(0.6)

Хөрөнгийн албан татвар	29.8	31.3	(1,5)
Бууны албан татвар	2.8	2.3	0.5
Иргэдийн мөнгөн хадгаламжийн хүүгийн орлого	27,0	29,0	(2,0)
Малын хөлийн албан татвар	-	-	
Бусад татвар, төлбөр, хураамж	3.4	17.3	(13,9)
Улсын тэмдэгтийн хураамж	2.0	16.2	(14,2)
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны	0.3	0.1	0.2
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	1.1	1.0	0.1
Газрын төлбөр	0.5	0.2	0.3
Газрын төлбөр	0.5	0.2	0.3
Байгалийн нөөц ашигласны төлбөр	117.8	228.0	(110,2)
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	116.3	227.9	(111,6)
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	0.5		0.5
Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	1.0	0.2	0.8
Татварын бус орлого	1.0	4.0	(3,0)
Нийтлэг татварын бус орлого	1.0	4.0	(3,0)
Торгуулийн орлого	1.0	4.0	(3,0)

Эх сурвалж: Мөст сумын ТТЗ-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт орлого 298.2 сая төгрөгөөр буюу 135.2 сая төгрөгөөр давуулжээ. Орлого давсан шалтгаан нь үйл ажиллагааны орлого 9.7 сая төгрөг, шууд бус орлого 0.6 сая төгрөг, иргэдийн хадгаламжийн хүүгийн орлого 2.0 сая төгрөг, Улсын тэмдэгтийн хураамжийн орлого 14.2 сая төгрөг, ан амьтан ашигласны төлбөр 111.6 сая төгрөгөөр хүү торгуулийн орлого 3.0 сая төгрөгөөр давуулан биелүүлж хувь хүний орлогын албан татвар 3.4 сая төгрөгөөр, бууны албан татвар 0.5 сая төгрөгөөр, ус рашааны төлбөр 0.5 сая төгрөгөөр, байгалийн ургамал ашигласны төлбөр 0.8 сая төгрөг тус тус тасарсан орлого нэр төрлөөр тасрах үндсэн шалтгаан болжээ.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн тайлангаар ЭМДС-аас Ковид-19 цар тахлын илүү цаг урамшуулал, эмийн зардалд 74.6 сая төгрөг, аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 17.6 сая төгрөг, дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 79.8 сая төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд 12.7 сая төгрөг, бусад орлогоос 18.0 сая төгрөг нийт 202.7 сая төгрөгийн орлого бүрдүүлэн 195.1 сая төгрөгийг зарцуулж орон нутгийн төсөвт 7.6 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Мөст сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайланд тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай дараах асуудлууд байна. Үүнд:

1. Сум хөгжүүлэх сангийн 2011-2021 онуудад олгосон 92 зээлдэгчид 427.5 сая төгрөгийн зээл олгосноос нас барсан 1 иргэний 4.0 сая төгрөг төлөгдөөгүй, 27 иргэн зээлээ бүрэн төлж дууссан 14 иргэний 42.1 сая төгрөгийн зээлийн төлөх хугацаа болоогүй 50 иргэн, аж ахуйн нэгжийн 129.0 сая төгрөгийн зээлийн авлага нь хугацаа хэтэрч сангийн хөрөнгийн эргэцийг удаашруулж, хөрөнгийн үр өгөөжийг бууруулж байна.

2. Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх тэмцэхтэй холбоотой хувь иргэн, ААН, байгууллагуудаас 0.8 сая төгрөгийн бэлэн мөнгө хандивласан байна.
3. Тайланд хугацаанд 378 хүн Ковид-19 цар тахлаар өвчилж 17.2 сая төгрөгийн нэг удаагийн эм, эмнэлгийн хэрэгсэл урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулсан байна.

3.8 Аудитын гол асуудал

Мөст сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайланд улсын төсвөөс санхүүждэг Мөст сумын сум дундын эмнэлгийг Эрүүл мэндийн сайдын тушаалаар орон нутагт шилжүүлсэнтэй холбоотойгоор тус байгууллагын санхүүгийн тайлангийн эхний үлдэгдлийг данс бүртгэлд тусгасан нь санхүүгийн тайланд үлэмж нөлөө үзүүлсэн байна

Засгийн газрын 43 дугаар тогтоолын дагуу батлагдсан төсөвт зардлын 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргаагүй, төсөвт төвлөрүүлээгүй байна. Энэ нь Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны 43 дугаар тогтоолын 1.1-д "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" гэж заасан заалтыг хэрэгжүүлээгүйтэй холбоотой байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000 нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс 90 мэдээллийг хугацаандаа оруулсан, 58 мэдээллийг хугацаа хоцроосон 3 мэдээллийг мэдээлэлгүй байна. Аймгийн хэмжээнд сум хөгжүүлэх сангийн Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг мэдээлэх тусгай цэсгүйгээс тайлант онд орсон орлогын гүйлгээг мэдээлээгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 197.5 сая төгрөгийн 1 албан шаардлагын хэрэгжилт 50 хувьтай, 196.3 сая төгрөгийн 3 зөвлөмжийн хэрэгжилт 90 хувьтай хэрэгжүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар Ковид-19 цар тахал, Шүлхий өвчинтэй холбоотой сумын төсөвт байгууллагуудаас гаргасан зардлын зарцуулалт, авч үзэх нь зүйтэй байна.

3.12 Харьяа байгууллагуудын аудитын дүнгийн талаар

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 2 тусгай сан, нийт 8 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 3 байгууллагыг аудитад хамруулан дүгнэлт гаргаж, 5 тайланг түүвэрт хамруулсан байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” 2 (сумын 12 жилийн сургууль, сумын хүүхдийн цэцэрлэг), “Сөрөг” 1 (сум дундын эмнэлэг) нийт 3 дүгнэлт гаргасан байна.

Мөст сумын ТТЗ-ын нэгтгэлд хамрагдсан төсвийн шууд захирагчдын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 398 сая төгрөгийн 16 алдаа зөрчил илэрч, 125.5 сая төгрөгийн 8 алдааг залруулсан байна.

Залруулагдаагүй 272.5 сая төгрөгийн 8 алдаа зөрчлөөс 196.5 сая төгрөгийн 3 алдаа зөрчилд албан шаардлага, 76.0 сая төгрөгийн 5 алдаа зөрчилд зөвлөмж өгөгдсөн байна. Нийт алдаа зөрчил, шийдвэрлэлтийг хүснэгтээр харуулбал:

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Мөст сумын 12 жилийн сургууль	4	57.0	3	57.0					1	-
2	Мөст сумын хүүхдийн цэцэрлэг	4	52.9	3	52.90					1	-
3	Мөст сумын ЭМТ	8	288.1	2	15.6			3	196.5	3	76.0
Дүн		16	398.0	8	125.5			3	196.5	5	76.0

Эх сурвалж: Мөст сумын ТШЗ-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

4. Нэгтгэсэн тайлангийн аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 463.7 сая төгрөгийн 18 алдаа зөрчил илэрснээс 276.7 сая төгрөгийн 9 алдааг залруулж, 0.6 сая төгрөгийн 1 алдаа зөрчилд төлбөрийн акт, 129.0 сая төгрөгийн 2 алдаа зөрчилд албан шаардлага, 5 алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 57.4 сая төгрөгийн 6 зөвлөмж өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- ОНХС-гийн авлагыг 2.0 сая төгрөгөөр дутуу тайлагнасан, өр төлбөрийг 2.0 сая төгрөгөөр илүү бүртгэсэн, дуусаагүй ажлуудыг авлага дансанд бүртгээгүйтэй холбоотойгоор 100.0 сая төгрөгийг урьдчилгаа дансанд бүртгэсэн, үр дүнгийн тайланд орлогыг 56.8 сая төгрөгөөр дутуу илэрхийлснийг залруулсан, тайлант оны үр дүнг 77.7 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн нийт 238.5 сая төгрөгийн 5 алдааг залруулсан.
- СХС-гийн тайланд зээлийн авлагыг 4.8 сая төгрөгөөр дутуу илэрхийлсэн, үр дүнгийн тайланд орлогыг 5.9 сая төгрөгөөр дутуу илэрхийлсэн, тайлант оны үр дүнг 4.8 сая төгрөгөөр дутуу илэрхийлсэн нийт 15.5 сая төгрөгийн 3 алдааг залруулсан.
- Сумын ЗДТГ нь жолоочийн замын хуудас бодуулаагүйтэй холбоотой 22.7 сая төгрөгийн алдааг залруулсан.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын удирдлага, нягтлан бодогч нарт асуудлын бүртгэлээр танилцуулан 276.7 сая төгрөгийн залруулга хийж, залруулсан 2022 оны 01 дүгээр сарын 27-ны 1/12 тоот албан бичгээр санхүүгийн тайланд залруулга хийсэн болно.

4.2 Төлбөрийн акт

Тайлант онд ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн сумын төвийн авто зогсоол, эмнэлгийн хашаа хийх ажлуудыг санхүүжүүлэхдээ техник хяналтын зардлыг суутган

аваагүй зөрчил дутагдал илэрлээ. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4.2.-д “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлагыг нягтлан бодох бүртгэлд заавал бүртгэнэ” гэсэнтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: 0.6 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоов.

4.3 Албан шаардлага

4.3.1. Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой.

Илрүүлэлт Сумын ЗДТГ нь Шилэн дансны цахим системд оруулбал зохих мэдээллийг цаг хугацаанд нь бүрэн мэдээлээгүй Үүнд:1. ТГТ зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийн дүн, хэтрэлт хэмнэлт, тайлбарыг 2, 3 дугаар улиралд дутуу мэдээлсэн, 1, 2, 4 дүгээр улирлыг мэдээлээгүй 2. 2021 оны хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан оруулаагүй, 3. 2020 оны аудитын дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийг хэрхэн ханган ажиллаж байгаа талаар мэдээлээгүй, 4. 5 сая төгрөгөөр дээш цалингаас бусад үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээг мэдээлээгүй байгаа нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах албан шаардлага хүргүүлэв.

4.3.2. Сум хөгжүүлэх сангийн авлагатай холбоотой

Илрүүлэлт: СХС-аас зээл аваад хугацаа хэтэрсэн 50 зээлдэгчтэй холбоотой 129.0 сая төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна. Энэ нь нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 5.4-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д " төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" заалтууд болон сум хөгжүүлэх сангаас олгох барьцаат зээлийн гэрээний 2.2-д "зээлийн үндсэн төлбөрийг дор дурдсан зээлийн эргэн төлөлтийн дагуу төлж дуусгана", 2.4-д" энэхүү гэрээний 2.2-д заасан зээлийн эргэн төлөлтийн хуваарьт заасан хугацаанд зээлийн үндсэн төлбөр, хүүгээс гадна төлөгдөөгүй үндсэн зээлийн хугацаа хэтрүүлсэн хоног тутамд зээлийн дүнгийн 0.5 хувийн алданги төлнө.", 5.3-д "энэхүү гэрээтэй холбогдсон аливаа маргаантай асуудлыг 2 тал харилцан тохиролцож шийдвэрлэх бөгөөд ийнхүү шийдвэрлэх боломжгүй бол асуудлыг шүүхээр шийдвэрлүүлнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Гэрээний үүргээ биелүүлээгүй зээлдэгч нарыг хуулийн байгууллагад хандан шийдвэрлэн ажиллаж сангийн хөрөнгийн эргэцийг сайжруулж үр өгөөжийг нэмэгдүүлэн ажиллах албан шаардлага хүргүүлэх

4.4. Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

4.4.1. Бараа материалын бүртгэлтэй холбоотой

Илрүүлэлт: ЗДТГ нь бараа материал худалдан авахад нярав нь орлого авч зарцуулалтын тайлан гаргаагүй үлдэгдлийг баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-д “нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэнтэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Бараа материалын тайланг байгууллагын нярваар гаргуулан сар бүр тооцоо хийх

4.4.2.Төсвийн зарцуулалттай холбоотой

Илрүүлэлт: ЗДТГ нь Засгийн газрын 2021 оны 43 тоот тогтоолыг зөрчин хөрөнгө бэлтгэсэн, батлагдсан төсөвт зардлын 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргаж ажиллаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” Засгийн газрын 2021 оны 43 тоот тогтоолын 1.1-д “Үндсэн үйл ажиллагаатай холбоотой зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл арга хэмжээг тэвчиж зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” гэсэнтэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хууль болон Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлэн ажиллах

4.4.3.ОНХС-гийн хөрөнгийн зарцуулалттай холбоотой.

Илрүүлэлт: ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээнд иргэдийн санал аваагүй ИТХ-ын төлөөлөгчдийг чадавхжуулах хөтөлбөр арга хэмжээнд 5.0 сая төгрөгийг тусгаж санхүүжүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 60.3.6-д “орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглоно” гэсэнтэй нийцэхгүй байна.

Өгөгдсөн зөвлөмж: ОНХС-гийн хөрөнгийг төлөвлөх, батлуулах, зарцуулахдаа иргэдийн санал аваагүй ажил, хөтөлбөр, арга хэмжээг тусгахгүй байх

4.4.4 ОНХС-гийн зарцуулалттай холбоотой асуудал

Илрүүлэлт: ОНХС-гаас Гамшгаас хамгаалах, Ковид-19 цар тахалтай холбоотойгоор 15.0 сая төгрөгийг болзошгүй арга хэмжээнд зориулан баталж зарцуулсан байгаа нь Гамшгаас хамгаалах тухай хуулийн 51.4-д “Улсын хэмжээнд гамшгаас хамгаалах төвлөрсөн арга хэмжээний зардлыг улсын төсвөөс, аймаг, нийслэл, сум, дүүргийн гамшгаас хамгаалах арга хэмжээний зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээд зардлаа өөрөө хариуцна” гэсэнтэй нийцээгүй

Өгсөн зөвлөмж: ОНХС-гийн төлөвлөгөөнд гамшгийн зардлыг тусгахгүй байх, Гамшгаас хамгаалах тухай хуулийн хэрэгжүүлэн ажиллаж холбогдох зардлыг орон нутгийн төсвөөс шийдвэрлэн ажиллах.

4.4.5 Дотоод хяналттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тус сумын эмнэлэг нь санхүүгийн тайлангийн аудитаар “Сөрөг” санал дүгнэлт авсан, өр төлбөр 73.3 сая төгрөгийн өр төлбөртэй байна.

Өгсөн зөвлөмж: Сумын Засаг дарга ажлын хэсэг томилон Мөст сумын сум дундын эмнэлэгт дотоод хяналтыг хэрэгжүүлэн өр төлбөрийг барагдуулан ажиллах

4.4.6 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт:

Илрүүлэлт: Сумын ТТЗ нь Шилэн дансны сайтад тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс 90 мэдээллийг хугацаандаа оруулсан, 58 мэдээллийг хугацаа хоцроосон 3 мэдээллийг мэдээлэлгүй байна. Аймгийн хэмжээнд сум хөгжүүлэх сангийн Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг мэдээлэх тусгай цэсгүйгээс тайлант онд орсон

орлогын гүйлгээг мэдээлээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-тай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллаж хуульд заасан мэдээллийг тогтоосон хугацаанд нь иж бүрэн, үнэн зөв оруулж хэвших

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 6 дүгээр сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

ТТЗ болон түүвэрт хамрагдсан байгууллагын алдаа зөрчлийн нэгтгэл Хүснэгт-6 /сая. төгрөгөөр/

д/д	байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Мөст ЗДТГ	4	60.1	1	22.7	-	-	1	-	2	37.4
2	Мөст ИТХ	-	-								
3	Мөст Соёлын төв	-	-								
4	Мөст ОНХС	7	244.1	5	238.5	1	0.60	-	-	1	5.0
5	Мөст СХС	4	144.5	3	15.5			1	129.00	-	-
6	ТТЗ	3	15.0			-	-	-	-	3	15.0
	Дүн	18	463.7	9	276.7	1	0.60	2	129.00	6	57.40

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР